



Албан хэрэгцээнд

“Сэнд Эм Эн ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 02 сарын 05 өдрийн  
24/04 тоот тогтоолын хавсралт 2

**“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ИЙН  
ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО**

**2024 он**

Баримт бичиг код: SE/BD/01/POL/24

Баримт бичиг нэр: “Сэнд Эм Эн ББСБ”ХХК-ийн  
Залгамж халааны бодлого

Хувилбар: 01

Хянасан огноо: 2024

Ангилал: Албан хэрэгцээнд

## Өөрчлөлтийн түүх:

| Хувилбар | Батлагдсан огноо,<br>тушаалын дугаар | Өөрчлөлтийн тайлбар | Боловсруулсан                                      | Хянасан                |
|----------|--------------------------------------|---------------------|--|------------------------|
| 01       | 2024.02.05<br>№24/04                 |                     | Хуульч/ТУЗ-ийн<br>нарийн бичгийн<br>дарга Ц.Ундрах | Гүйцэтгэх<br>удирдлага |



## “СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ИЙН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Сэнд Эм Эн ББСБ” ХХК-ийн Залгамж халааны бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго “Сэнд Эм Эн ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн эрх бүхий болон түлхүүр албан тушаалтны залгамж халааг урьдчилан бэлтгэх, хөгжүүлэх, сургахад оршино.
- 1.2. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан гэдэгт Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтнаас гадна компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийн хэрэгжилтэд чухал ач холбогдолтой албан тушаалтнуудыг хамруулан ойлгоно.
- 1.3. Компани нь мэргэжлийн өндөр ур чадвартай, хариуцлагатай, мэргэшсэн боловсон хүчний нийлүүлэлтийг хангахын тулд ажилтнуудад сургалт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, түлхүүр ажлын байранд тохирох хүний нөөцийг бэлтгэхийг зорино.
- 1.4. Бодлогын ач холбогдлыг Компанийн бүх ажилтнуудад сурталчлан таниулахад Гүйцэтгэх чухал үүрэгтэй.

### Хоёр. Хэрэгжүүлэх үйл явц

- 2.1. Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь Бодлогын хэрэгжилтийг хангуулан хэрэгжилтэд хяналт тавьж, нэр дэвшигчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг баталж, залгамж бэлтгэх үйл явцад дэмжлэг үзүүлж ажиллана.
- 2.2. Захиргаа, хүний нөөцийн алба нь эрх бүхий болон түлхүүр албан тушаалтантай хамтран залгамж халааг бэлтгэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-д танилцуулна.
- 2.3. Эрх бүхий болон түлхүүр албан тушаалтан нь өөрийн залгамж халааг бэлтгэхийн тулд гаднаас болон компанийн хүний нөөцөөс өөрийн ажлын байранд тохирох 1-2 нэр дэвшигчийг тодорхойлж, Компанийн бизнес төлөвлөгөө, Хүний нөөцийн бодлого зэрэг баримт бичгүүдтэй уялдуулан Бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4. Захиргаа, хүний нөөцийн алба нь урт хугацааны чөлөө авах, богино хугацаанд томилолтоор дотоод, гадаадад ажиллах, ээлжийн амралт авах, жирэмсний амралт авах гэх мэт таамаглаж болохуйц эрх бүхий болон түлхүүр ажлын байрны хэрэгцээг урьдчилан төлөвлөх, шат дараалалтай арга хэмжээ авахыг жилд нэгээс доошгүй удаа судалгаа авч, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад танилцуулна.
- 2.5. ТУЗ нь эрх бүхий ажилтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үр дүнд улираан дэвшүүлэх, дэвшүүлэх саналыг гаргана.
- 2.6. ТУЗ нь Бодлоготой нийцүүлэн компанийн дотоод журам, зааврыг хэлэлцэж, зөвлөмж гаргана.

### Гурав. Бусад

- 3.1. Бодлогын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж, гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

